- 5.6. Хог хаягдлыг ангилан ялгах, хураах, тээвэрлэх, зөөх зэрэг процессыг хамарсан хог хаягдлын орчин үеийн менежментийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлнэ, иргэдэд хогоо ялгаж хийх, зөв зохистой хаях дадлыг хэвшүүлэх маркетингийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.7. Хороодын нутаг дэвсгэрт байгаа гудамж талбайн нэн шаардлагатай хэсгүүдэд хогийн савны хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.8. Дүүргийн дэвсгэрт байгаа ил задгай асгадаг хогийн цэгийг цэгцэлнэ.

##### Аюулгүй, амар тайван, ая тухтай дүүргийн шийдэл

- 5.9. Дүүргийн нэн шаардлагатай тодорхой байршил, хэсгүүдийг бүрэн камержуулна.
- 5.10. Хороодын нутаг дэвсгэрт байгаа гудамж, талбайн гэрэлтүүлгийн тоог эрс нэмэгдүүлнэ.

3 / 5



*J. Сахаров*


- 5.11. Иргэдийн амар тайван амьдрахад саад болж буй шөнийн цагаар дуу ихтэй мотоцикл, автомашин явахыг хориглоно. Автомашин, мотоциклын дуу чимээний хотын стандартыг бий болгож, мөрдүүлнэ.
- 5.12. Явган хүний зам талбайг хааж, хашсан хашаа, зөвшөөрөлгүй баригдсан, байрлуулсан барилга байгууламжуудыг буулгаж, нийтийн эзэмшлийн газрыг чөлөөлөн тохижуулна.
- 5.13. Хүүхэд, сурагчдын ихээр зорчдог хэсгүүдийн явган хүний зам талбайг тохижуулж, авто замын гарцуудыг шинэчилнэ.
- 5.14. Айл гэр, албан газарт архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж байгааг бууруулахад чиглэсэн нөлөөллийн аян, урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- 5.15. Онцгой байдлын дуудлагад чөлөөтэй очих нөхцөлөөр ханган автомашин орж гарах замыг чөлөөлнө.
- 5.16. Үерийн уснаас сэргийлж эрсдэл өндөртэй хэсгүүдэд ус зайлуулах шугамыг шинэчлэн сайжруулна. Ус зайлуулах шугамыг шинэчилж, эрсдэл өндөртэй газруудад үерийн усны зайлуулагч бий болгоно.
- 5.17. Дүүргийн зарим автобусны буудлуудыг стандартын дагуу тохижуулах ажлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.
- 5.18. Гэр хорооллын дэд бүтэц, орчин нөхцлийг сайжруулна.
- 5.19. Хороодод спортын талбай, номын сан, амралт чөлөөт цаг, хувь хүнийг хөгжүүлэх цэгүүдийг бий болгох, одоо байгааг шинэчлэн тохижуулна.

#### 6. Иргэндээ ээлтэй дүүрэг

- 6.1. Дүүргийн хэмжээнд хүүхдийн тоглоомын талбайг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 6.2. Зам тээврийн осол аваараас сэргийлж сургууль, цэцэрлэгийн бүсүүдэд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу нэмж байршуулна.
- 6.3. Сурагчдын бие биедээ хүндэтгэлтэй хандах, бусдыг дээрэлхэхгүй байх аяныг дүүргийн төрийн өмчит болон хувийн сургуулиудын дэмжлэгтэйгээр зохион байгуулна.
- 6.4. Хүүхэд залуусын соёл, амралтын цогцолбор байгуулна.
- 6.5. Ахмадуудын чөлөөт цагаа зохистой өнгөрөөх Ахмадын хөгжлийн төвүүдийг бий болгох, орчин нөхцөлийг сайжруулан тэдэнд зориулсан хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 6.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцлийг бүрдүүлсэн дүүрэг болно.

#### 7. Бизнесийг дэмждэг дүүрэг

- 7.1. Өөрийн давуу талд тулгуурлан хүнс хөнгөн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, барилга, тээвэр логистик, мэдээллийн технологийн чиглэлийг Сонгинохайрхан дүүргийн бизнесийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.
- 7.2. Дүүргийн ажилгүй иргэдийг сургалтад хамруулах, иргэдэд ажлын байрны мэдлэг ур чадвар олгох, тасралтгүй хөгжүүлэх ажлыг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх, тухайн хугацаанд олон ажлын байрыг бий болгосон ёс зүйтэй ажил олгогчдыг хөхиүлэн дэмжиж, олон нийтэд сурталчилна.




*Handwritten signature*



- 7.3. Өрхийн үйлдвэрлэл, аж ахуйн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, нөхөрлөл, хоршоодыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны түншлэлийн хүрээнд хөхиүлэн дэмжиж ажиллана.
- 7.4. Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллагуудаас төрийн үйлчилгээ, бизнесийн дэмжлэгийн эрэлт хэрэгцээний талаар судалгааг тогтмолжуулж, судалгааны үр дүнгээр бизнесийг дэмжих зорилтыг хэрэгжүүлнэ.
- 7.5. Бизнес эрхлэгчдэд аливаа дарамт, шахамт үзүүлэхгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэнэ.
- 7.6. Төрийн байгууллага, төрийн үйлчилгээний бүхий л түвшинд авилга, хүнд суртлыг бууруулах бодлогыг дэмжиж, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг холбогдох байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.
- 7.7. Үйлдвэрлэгч болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин үзэсгэлэн худалдааг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд тогтмол хугацаанд зохион байгуулна.
- 7.8. Ажил хөдөлмөрт зуучлалын нэгдсэн цахим мэдээллийн сантай болж ажил олгогч, ажилд горилогчдыг дэвшилтэт аргаар холбоно.
- 7.9. Иргэдийн бизнес эрхлэх идэвх санаачилгыг бий болгох, бизнесийг нь бойжуулж хөгжүүлэх зорилгоор хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд бизнесийн зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулж, менторшип хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлнэ.
- 7.10. Зорилтот бүлгүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орчин үеийн төсөл, хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлнэ.

## 8. Ногоон орчинтой дүүрэг

- 8.1. Дүүргийн хэмжээнд гэр хороолол, орон сууцны хороолол болон нийтийн эзэмшлийн талбай дахь ногоон байгууламжийг эрс нэмэгдүүлнэ.
- 8.2. Дүүргийн хэмжээнд орчим байршилд бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
- 8.3. Орон сууц болон гэр хорооллын гудамж талбайд шинээр мод тарьсан, ногоон байгууламжийг бий болгосон сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийг хөхиүлэн дэмжинэ.



*Handwritten signature*



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 925  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ҮНДЭСНИЙ  
ЭВСЭЛД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Налайх дүүргийн “Үндэсний эвсэл”-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Налайх дүүргийн “Үндэсний эвсэл”-ийн Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад шаардлагад тус тус нийцсэн байна.

Налайх дүүргийн “Үндэсний эвсэл”-ийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Налайх дүүргийн сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



# НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ЭЭС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

“ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН”  
“ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ ДЭМЖЬЕ”  
“ҮНДЭСТНЭЭРЭЭ БАЯЖЬЯ”



ЭВ УХААНААР ЗАСАГЛАЯ

ЧАДДАГААР НЬ ХИЙЛГЭЕ

ХОТЛООРОО БАЯЖЬЯ

НИЙСЛЭЛЭЭ НОГООРУУЛЪЯ



*Handwritten signature*

## МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### 1. Цогц төлөвлөлт, цомхон удирдлага, цахим засаглалтай дүүрэг


- 1.1. Нийслэлийн хотын цогц төлөвлөлтөд нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэлтэй, орчин үеийн шийдлийг тусгасан, төсөв хөрөнгийн зөв тооцоололтой байх зарчмыг дүүргийн удирдлагад баримтална.
- 1.2. Дүүргийн иргэдэд үзүүлэх үйлчилгээ, иргэдийн санал хүсэлт, санаачилгыг хүлээн авч, шийдвэрлэх механизмыг бүрэн цахимжуулна.
- 1.3. Дүүргийн удирдлагын үйл ажиллагааг цахимжуулах, дүүрэг болон хороодын ажлын байрны зураг авалтыг хийж, бодит орон тоог тогтоон, одоогийн данхайсан орон тоог эрс багасгана.
- 1.4. Дүүрэг болон хороодын нийт ажиллагсдыг аттестатчилалд хамруулж, “чаддагаар нь хийлгэх” зарчмыг баримтлан хүний нөөцийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.5. Иргэдийн амьдрах нөхцөл байдлаа сайжруулах санал санаачилга, төсөл хөтөлбөрийг дэмжин, ардчилалын зарчмаар олонхын санал дээр үндэслэн хэрэгжүүлнэ.

### 2. Суурь шийдэлтэй дүүрэг

- 2.1. Төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр хийгдэх бүтээн байгуулалт, зам талбай, тохижилтын ажлуудын гүйцэтгэлд хяналт тавьж, иргэдийн оролцоотой хариуцлагын тогтолцоог бий болгон хэрэгжүүлж, олон нийтэд ил тод мэдээллэх механизмыг бүрдүүлнэ.
- 2.2. Гэр хорооллын бүсүүдэд зөөврийн ус түгээх байруудад ухаалаг төхөөрөмж байрлуулж, тоолууржуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Усны хангамжийн асуудлыг орчин үеийн дэд бүтцийг бий болгох зорилтын хүрээнд шийдвэрлэнэ.
- 2.3. Зам талбай, цахилгаан, дулаан, усны шугам хоолой засварын ажлуудын төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналтад иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, нийслэлийн хөрөнгө оруулалтын газар болон барилга, цахилгаан, тохижилт үйлчилгээний газрууд хоорондын нягт уялдаа холбоог бий болгон хамтран ажиллана. Уялдаа холбоогүйгээс шалтгаалан хийгдсэн нэг ажлыг хийгдэх нөгөө ажил нь сүйтгэдэг өнөөгийн байдлыг бүрэн арилгана.
- 2.4. Ашиглалтын насжилт өндөртэй орон сууцны засвар үйлчилгээг нэн шаардлагатай газруудад үе шаттайгаар хийнэ.

### 3. Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд

- 3.1. Төрийн өмчийн сургуульгүй хороодод сургууль барих зорилтыг хэрэгжүүлнэ. Сургуулийн хүртээмж муутай 4 ба 7-р хороодод сургууль барих буюу хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.2. Цэцэрлэгийн хүртээмж муутай хороодод хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулна.
- 3.3. Дүүргийн 4-р хороонд төрийн өмчийн цэцэрлэгийг барих зорилтыг хэрэгжүүлнэ.
- 3.4. Хичээлийн бус чөлөөт цагаар сурагчдыг урлаг, спорт, хувь хүний хөгжил чиглэлээр Хүүхэд хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



*S. Seren*

- 3.5. Сургууль, цэцэрлэгт шаардлагатай сургалтын болон орчны тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийнэ.

#### 4. Эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд

- 4.1. Өрхийн эрүүл мэндийн цогцолборыг 2 ба 7-р хороонд өргөтгөн шинэчилнэ.
- 4.2. Жирэмсэн, бага насны хүүхэдтэй эхчүүдийн мэдээллийг цахимжуулж, эрүүл мэндийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ.
- 4.3. Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээг үйлчилгээг чанаржуулах зорилгоор үйлчлүүлэгчдийн сэтгэгдэл, санал хүсэлтийг тандан судалж, түүнд үндэслэн сайжруулах механизм бүрдүүлнэ.
- 4.4. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор нийтийн биеийн тамирыг хүн бүрийн амьдралын дадал болгох зорилго бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

#### 5. Тааламжтай орчинтой дүүрэг

##### Түгжрэлгүй дүүргийн шийдэл


- 5.1. Дүүргийн шаардлагатай байршлуудад автомашины зогсоолын тоог нэмэгдүүлнэ.
- 5.2. Зохиомол түгжрэл үүсгэж буй зогсохыг хориглосон газар удаан хугацаагаар тээврийн хэрэгслээ байрлуулдаг асуудлыг шийдвэрлэх цогц хөтөлбөр боловсруулна.
- 5.3. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдод зориулсан зогсоолыг тохижуулж GPS төхөөрөмжийг байршуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.
- 5.4. Дүүргийн нутаг дэвсгэр дээрх авто замын сүлжээг өргөтгөх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

##### Хоггүй, бохирдолгүй дүүргийн шийдэл

- 5.5. Дүүргийн гудамж талбайн цэвэрлэгээнд орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлнэ, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлнэ.
- 5.6. Хог хаягдлыг ангилан ялгах, хураах, тээвэрлэх, зөөх зэрэг процессыг хамарсан хог хаягдлын орчин үеийн менежментийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлнэ, иргэдэд хогоо ялгаж хийх, зөв зохистой хаях дадлыг хэвшүүлэх маркетингийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.7. Хороодын нутаг дэвсгэрт байгаа гудамж талбайн нэн шаардлагатай хэсгүүдэд хогийн савны хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.8. Дүүргийн дэвсгэрт байгаа ил задгай асгадаг хогийн цэгийг цэгцэлнэ.

##### Аюулгүй, амар тайван, ая тухтай дүүргийн шийдэл

- 5.9. Дүүргийн нэн шаардлагатай тодорхой байршил, хэсгүүдийг бүрэн камержуулна.
- 5.10. Хороодын нутаг дэвсгэрт байгаа гудамж, талбайн гэрэлтүүлгийн тоог эрс нэмэгдүүлнэ.



*А. Оюун*


- 5.11. Иргэдийн амар тайван амьдрахад саад болж буй шөнийн цагаар дуу ихтэй мотоцикл, автомашин явахыг хориглоно. Автомашин, мотоциклын дуу чимээний хотын стандартыг бий болгож, мөрдүүлнэ.
- 5.12. Иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Туул голын дагуух үер, уснаас хамгаалах даланг засварлана.
- 5.13. Туул голын эргийн дагуу хотын иргэдийн амралт чөлөөт цагийг боловсон өнгөрүүлэх бүсийг бий болгоно.
- 5.14. Хүүхэд, сурагчдын ихээр зорчдог хэсгүүдийн явган хүний зам талбайг тохижуулж, авто замын гарцуудыг шинэчилнэ.
- 5.15. Айл гэр, албан газарт архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж байгааг бууруулахад чиглэсэн нөлөөллийн аян, урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- 5.16. Үөрийн уснаас сэргийлж эрсдэл өндөртэй хэсгүүдэд ус зайлуулах шугамыг шинэчлэн сайжруулна. Ус зайлуулах шугамыг шинэчилж, эрсдэл өндөртэй газруудад үөрийн усны зайлуулагч бий болгоно.
- 5.17. Гэр хорооллын дэд бүтэц, орчин нөхцлийг сайжруулна.
- 5.18. Хороодод спортын талбай, номын сан, амралт чөлөөт цаг, хувь хүнийг хөгжүүлэх цэгүүдийг бий болгох, одоо байгааг шинэчлэн тохижуулна.

## 6. Иргэндээ ээлтэй дүүрэг

- 6.1. Дүүргийн хэмжээнд хүүхдийн тоглоомын талбайг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 6.2. Зам тээврийн осол аваараас сэргийлж сургууль, цэцэрлэгийн бүсүүдэд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу нэмж байршуулна.
- 6.3. Сурагчдын бие биедээ хүндэтгэлтэй хандах, бусдыг дээрэлхэхгүй байх аяныг дүүргийн төрийн өмчит болон хувийн сургуулиудын дэмжлэгтэйгээр зохион байгуулна.
- 6.4. Хүүхэд залуусын соёл, амралтын цогцолбор байгуулна.
- 6.5. Ахмадуудын чөлөөт цагаа зохистой өнгөрөөх Ахмадын хөгжлийн төвүүдийг бий болгох, орчин нөхцөлийг сайжруулан тэдэнд зориулсан хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 6.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцлийг бүрдүүлсэн дүүрэг болно.

## 7. Бизнесийг дэмждэг дүүрэг


- 7.1. Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, худалдаа тээвэр логистикийн чиглэлийг Налайх дүүргийн бизнесийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.
- 7.2. Дүүргийн ажилгүй иргэдийг сургалтад хамруулах, иргэдэд ажлын байрны мэдлэг ур чадвар олгох, тасралтгүй хөгжүүлэх ажлыг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх, тухайн хугацаанд олон ажлын байрыг бий болгосон ёс зүйтэй ажил олгогчдыг хөхиүлэн дэмжиж, олон нийтэд сурталчилна.
- 7.3. Өрхийн үйлдвэрлэл, аж ахуйн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, нөхөрлөл, хоршоодыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны түншлэлийн хүрээнд хөхиүлэн дэмжиж ажиллана.



- 7.4. Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллагуудаас төрийн үйлчилгээ, бизнесийн дэмжлэгийн эрэлт хэрэгцээний талаар судалгааг тогтмолжуулж, судалгааны үр дүнгээр бизнесийг дэмжих зорилтыг хэрэгжүүлнэ.
- 7.5. Бизнес эрхлэгчдэд аливаа дарамт, шахамт үзүүлэхгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэнэ.
- 7.6. Төрийн байгууллага, төрийн үйлчилгээний бүхий л түвшинд авилга, хүнд суртлыг бууруулах бодлогыг дэмжиж, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг холбогдох байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.
- 7.7. Үйлдвэрлэгч болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин үзэсгэлэн худалдааг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд тогтмол хугацаанд зохион байгуулна.
- 7.8. Ажил хөдөлмөрт зуучлалын нэгдсэн цахим мэдээллийн сантай болж ажил олгогч, ажилд горилогчдыг дэвшилтэт аргаар холбоно.
- 7.9. Иргэдийн бизнес эрхлэх идэвх санаачилгыг бий болгох, бизнесийг нь бойжуулж хөгжүүлэх зорилгоор хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд бизнесийн зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулж, менторшип хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлнэ.
- 7.10. Зорилтот бүлгүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орчин үеийн төсөл, хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлнэ.

#### 8. Ногоон орчинтой дүүрэг

- 8.1. Дүүргийн хэмжээнд гэр хороолол, орон сууцны хороолол болон нийтийн эзэмшлийн талбай дахь ногоон байгууламжийг эрс нэмэгдүүлнэ.
- 8.2. Орон сууц болон гэр хорооллын гудамж талбайд шинээр мод тарьсан, ногоон байгууламжийг бий болгосон сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийг хөхиүлэн дэмжинэ.



*[Handwritten signature]*





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
ҮНДЭСНИЙ ЭВСЭЛД

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 924  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Баянзүрх дүүргийн “Үндэсний эвсэл”-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Баянзүрх дүүргийн “Үндэсний эвсэл”-ийн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянзүрх дүүргийн “Үндэсний эвсэл”-ийн мөрийн хөтөлбөр /.....<sup>5</sup> хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Баянзүрх дүүргийн сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



# БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ЭЭС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

“ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН”  
“ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ ДЭМЖЬЕ”  
“ҮНДЭСТНЭЭРЭЭ БАЯЖЬЯ”



ЭВ УХААНААР ЗАСАГЛАЯ

ЧАДДАГААР НЬ ХИЙЛГЭЕ

ХОТЛООРОО БАЯЖЬЯ

НИЙСЛЭЛЭЭ НОГООРУУЛЬЯ



2024 он



*J. Орагч*

## МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### 1. Цогц төлөвлөлт, цомхон удирдлага, цахим засаглалтай дүүрэг


- 1.1. Нийслэлийн хотын цогц төлөвлөлтөд нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэлтэй, орчин үеийн шийдлийг тусгасан, төсөв хөрөнгийн зөв тооцоололтой байх зарчмыг дүүргийн удирдлагад баримтална.
- 1.2. Дүүргийн иргэдэд үзүүлэх үйлчилгээ, иргэдийн санал хүсэлт, санаачилгыг хүлээн авч, шийдвэрлэх механизмыг бүрэн цахимжуулна.
- 1.3. Дүүргийн удирдлагын үйл ажиллагааг цахимжуулах, дүүрэг болон хороодын ажлын байрны зураг авалтыг хийж, бодит орон тоог тогтоон, одоогийн данхайсан орон тоог эрс багасгана.
- 1.4. Дүүрэг болон хороодын нийт ажиллагсдыг аттестатчилалд хамруулж, “чаддагаар нь хийлгэх” зарчмыг баримтлан хүний нөөцийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.5. Иргэдийн амьдрах нөхцөл байдлаа сайжруулах санал санаачилга, төсөл хөтөлбөрийг дэмжин, ардчилалын зарчмаар олонхын санал дээр үндэслэн хэрэгжүүлнэ.

### 2. Суурь шийдэлтэй дүүрэг

- 2.1. Төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр хийгдэх бүтээн байгуулалт, зам талбай, тохижилтын ажлуудын гүйцэтгэлд хяналт тавьж, иргэдийн оролцоотой хариуцлагын тогтолцоог бий болгон хэрэгжүүлж, олон нийтэд ил тод мэдээллэх механизмыг бүрдүүлнэ.
- 2.2. Гэр хорооллын бүсүүдэд зөөврийн ус түгээх байруудад ухаалаг төхөөрөмж байрлуулж, тоолууржуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Усны хангамжийн асуудлыг орчин үеийн дэд бүтцийг бий болгох зорилтын хүрээнд шийдвэрлэнэ.
- 2.3. Зам талбай, цахилгаан, дулаан, усны шугам хоолой засварын ажлуудын төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналтад иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, нийслэлийн хөрөнгө оруулалтын газар болон барилга, цахилгаан, тохижилт үйлчилгээний газрууд хоорондын нягт уялдаа холбоог бий болгон хамтран ажиллана. Уялдаа холбоогүйгээс шалтгаалан хийгдсэн нэг ажлыг хийгдэх нөгөө ажил нь сүйтгэдэг өнөөгийн байдлыг бүрэн арилгана.
- 2.4. Ашиглалтын насжилт өндөртэй орон сууцны засвар үйлчилгээг нэн шаардлагатай газруудад үе шаттайгаар хийнэ.

### 3. Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд

- 3.1. Төрийн өмчийн сургуульгүй хороодод сургууль барих зорилтыг хэрэгжүүлнэ. Сургуулийн хүртээмж муутай хороодод 5 сургуулийг барьж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.2. Цэцэрлэгийн хүртээмж муутай хороодод хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулна.
- 3.3. Дүүргийн цэцэрлэгийн хүртээмж муу 11 хороодын (26, 28, 30-43-р хороо) 5 хороонд төрийн өмчийн цэцэрлэгийг барих зорилтыг хэрэгжүүлнэ.
- 3.4. Хичээлийн бус чөлөөт цагаар сурагчдыг урлаг, спорт, хувь хүний хөгжил чиглэлээр Хүүхэд хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



*Handwritten signature*

3.5. Сургууль, цэцэрлэгт шаардлагатай сургалтын болон орчны тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийнэ.

#### 4. Эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд

- 4.1. Өрхийн эрүүл мэндийн цогцолборыг 2 хороонд (6, 17-р) барина.
- 4.2. Жирэмсэн, бага насны хүүхэдтэй эхчүүдийн мэдээллийг цахимжуулж, эрүүл мэндийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ.
- 4.3. Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээг үйлчилгээг чанаржуулах зорилгоор үйлчлүүлэгчдийн сэтгэгдэл, санал хүсэлтийг тандан судалж, түүнд үндэслэн сайжруулах механизм бүрдүүлнэ.
- 4.4. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор нийтийн биеийн тамирыг хүн бүрийн амьдралын дадал болгох зорилго бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

#### 5. Тааламжтай орчинтой дүүрэг

##### Түгжрэлгүй дүүргийн шийдэл


- 5.1. Дүүргийн шаардлагатай байршлуудад автомашины зогсоолын тоог нэмэгдүүлнэ.
- 5.2. Зохиомол түгжрэл үүсгэж буй зогсохыг хориглосон газар удаан хугацаагаар тээврийн хэрэгслээ байрлуулдаг асуудлыг шийдвэрлэх цогц хөтөлбөр боловсруулна.
- 5.3. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдод зориулсан зогсоолыг тохижуулж GPS төхөөрөмжийг байршуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.
- 5.4. Дүүргийн нутаг дэвсгэр дээрх авто замын сүлжээг өргөтгөх болон төмөр зам доогуурх нүхэн гарцыг нэмэгдүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

##### Хоггүй, бохирдолгүй дүүргийн шийдэл

- 5.5. Дүүргийн гудамж талбайн цэвэрлэгээнд орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлнэ, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлнэ.
- 5.6. Хог хаягдлыг ангилан ялгах, хураах, тээвэрлэх, зөөх зэрэг процессыг хамарсан хог хаягдлын орчин үеийн менежментийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлнэ, иргэдэд хогоо ялгаж хийх, зөв зохистой хаях дадлыг хэвшүүлэх маркетингийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.7. Хороодын нутаг дэвсгэрт байгаа гудамж талбайн нэн шаардлагатай хэсгүүдэд хогийн савны хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.8. Дүүргийн дэвсгэрт байгаа ил задгай асгадаг хогийн цэгийг цэгцэлнэ.
- 5.9. Цагаан давааны хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах үйлдвэр барих ажлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

##### Аюулгүй, амар тайван, ая тухтай дүүргийн шийдэл


- 5.10. Дүүргийн нэн шаардлагатай тодорхой байршил, хэсгүүдийг бүрэн камержуулна.



- 5.11. Хороодын нутаг дэвсгэрт байгаа гудамж, талбайн гэрэлтүүлгийн тоог эрс нэмэгдүүлнэ.
- 5.12. Иргэдийн амар тайван амьдрахад саад болж буй шөнийн цагаар дуу ихтэй мотоцикл, автомашин явахыг хориглоно. Автомашин, мотоциклын дуу чимээний хотын стандартыг бий болгож, мөрдүүлнэ.
- 5.13. Иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Туул голын дагуух үер, уснаас хамгаалах даланг засварлана.
- 5.14. Туул голын эргийн дагуу хотын иргэдийн амралт чөлөөт цагийг боловсон өнгөрүүлэх бүсийг бий болгоно.
- 5.15. Явган хүний зам талбайг хааж, хашсан хашаа, зөвшөөрөлгүй баригдсан, байрлуулсан барилга байгууламжуудыг буулгаж, нийтийн эзэмшлийн газрыг чөлөөлөн тохижуулна.
- 5.16. Хүүхэд, сурагчдын ихээр зорчдог хэсгүүдийн явган хүний зам талбайг тохижуулж, авто замын гарцуудыг шинэчилнэ.
- 5.17. Айл гэр, албан газарт архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж байгааг бууруулахад чиглэсэн нөлөөллийн аян, урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- 5.18. Онцгой байдлын дуудлагад чөлөөтэй очих нөхцөлөөр ханган автомашин орж гарах замыг чөлөөлнө.
- 5.19. Үерийн уснаас сэргийлж эрсдэл өндөртэй хэсгүүдэд ус зайлуулах шугамыг шинэчлэн сайжруулна. Ус зайлуулах шугамыг шинэчилж, эрсдэл өндөртэй газруудад үерийн усны зайлуулагч бий болгоно.
- 5.20. Дүүргийн зарим автобусны буудлуудыг стандартын дагуу тохижуулах ажлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.
- 5.21. Гэр хорооллын дэд бүтэц, орчин нөхцлийг сайжруулна.
- 5.22. Хороодод спортын талбай, номын сан, амралт чөлөөт цаг, хувь хүнийг хөгжүүлэх цэгүүдийг бий болгох, одоо байгааг шинэчлэн тохижуулна.

## 6. Иргэндээ ээлтэй дүүрэг

- 6.1. Дүүргийн хэмжээнд хүүхдийн тоглоомын талбайг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 6.2. Зам тээврийн осол аваараас сэргийлж сургууль, цэцэрлэгийн бүсүүдэд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу нэмж байршуулна.
- 6.3. Сурагчдын бие биедээ хүндэтгэлтэй хандах, бусдыг дээрэлхэхгүй байх аяныг дүүргийн төрийн өмчит болон хувийн сургуулиудын дэмжлэгтэйгээр зохион байгуулна.
- 6.4. Хүүхэд залуусын соёл, амралтын цогцолбор байгуулна.
- 6.5. Ахмадуудын чөлөөт цагаа зохистой өнгөрөөх Ахмадын хөгжлийн төвүүдийг бий болгох, орчин нөхцөлийг сайжруулан тэдэнд зориулсан хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 6.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцлийг бүрдүүлсэн дүүрэг болно.




*А. Сүхбаатар*

## 7. Бизнесийг дэмждэг дүүрэг

- 7.1. Инновац шингэсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, ногоон агро парк, байгалийн болон соёлын аялал жуулчлалын чиглэлийг чиглэлийг Баянзүрх дүүргийн бизнесийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.
- 7.2. Дүүргийн ажилгүй иргэдийг сургалтад хамруулах, иргэдэд ажлын байрны мэдлэг ур чадвар олгох, тасралтгүй хөгжүүлэх ажлыг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх, тухайн хугацаанд олон ажлын байрыг бий болгосон ёс зүйтэй ажил олгогчдыг хөхиүлэн дэмжиж, олон нийтэд сурталчилна.
- 7.3. Өрхийн үйлдвэрлэл, аж ахуйн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, нөхөрлөл, хоршоодыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны түншлэлийн хүрээнд хөхиүлэн дэмжиж ажиллана.
- 7.4. Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллагуудаас төрийн үйлчилгээ, бизнесийн дэмжлэгийн эрэлт хэрэгцээний талаар судалгааг тогтмолжуулж, судалгааны үр дүнгээр бизнесийг дэмжих зорилтыг хэрэгжүүлнэ.
- 7.5. Бизнес эрхлэгчдэд аливаа дарамт, шахамт үзүүлэхгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэнэ.
- 7.6. Төрийн байгууллага, төрийн үйлчилгээний бүхий л түвшинд авилга, хүнд суртлыг бууруулах бодлогыг дэмжиж, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг холбогдох байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.
- 7.7. Үйлдвэрлэгч болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин үзэсгэлэн худалдааг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд тогтмол хугацаанд зохион байгуулна.
- 7.8. Ажил хөдөлмөрт зуучлалын нэгдсэн цахим мэдээллийн сантай болж ажил олгогч, ажилд горилогчдыг дэвшилтэт аргаар холбоно.
- 7.9. Иргэдийн бизнес эрхлэх идэвх санаачилгыг бий болгох, бизнесийг нь бойжуулж хөгжүүлэх зорилгоор хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд бизнесийн зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулж, менторшип хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлнэ.
- 7.10. Зорилтот бүлгүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орчин үеийн төсөл, хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлнэ.

## 8. Ногоон орчинтой дүүрэг

- 8.1. Дүүргийн хэмжээнд гэр хороолол, орон сууцны хороолол болон нийтийн эзэмшлийн талбай дахь ногоон байгууламжийг эрс нэмэгдүүлнэ.
- 8.2. Дүүргийн хэмжээнд 5 байршилд бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
- 8.3. Орон сууц болон гэр хорооллын гудамж талбайд шинээр мод тарьсан, ногоон байгууламжийг бий болгосон сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийг хөхиүлэн дэмжинэ.
- 8.4. Ногооны талбай, хүлэмжинд ногоо тарьж ургуулдаг иргэдийг хөхиүлэн дэмжиж, бүтээгдэхүүнийг зах зээлд худалдан борлуулах боломжийг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд бүрдүүлнэ.
- 8.5. Байгальд ээлтэй, ногоон бизнес эрхлэгчдийг дэмжиж, иргэд олон нийтэд сурталчилна.



*J. Dorj*



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 923  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Нийслэлийн “Үндэсний эвсэл”-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,



Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Нийслэлийн “Үндэсний эвсэл”-ийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад шаардлагад тус тус нийцсэн байна.

Нийслэлийн “Үндэсний эвсэл”-ийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэлийн сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



# НИЙСЛЭЛИЙН ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ЭЭС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

“ИРГЭН БАЯН БОЛ ХОТ БАЯН”

“ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭ ДЭМЖЬЕ  
ҮНДЭСТНЭЭРЭЭ БАЯЖЬЯ”



1. ЭВ УХААНААР ЗАСАГЛАЯ
2. ЧАДДАГААР НЬ ХИЙЛГЭЕ
3. ХОТЛООРОО БАЯЖЬЯ
4. НИЙСЛЭЛЭЭ НОГООРУУЛЬЯ



2024 он



*Handwritten signature*



## 1. ЭВ УХААНААР ЗАСАГЛАЯ




### 1.1. Цогц төлөвлөлт, цомхон удирдлагатай хот

Хотын хөгжил улсын хөгжлийн толь юм. Дэлхийн хотуудын хөгжлийн индексээр Монгол Улсын нийслэл хамгийн хөгжингүй хотоос даруй 2 дахин бага буюу 0.464 оноо авч, муу түвшинд үнэлэгджээ. Энэ нь эмц цэгцгүй, эрсдэлд тэсвэргүй, өрсөлдөх чадваргүй Улаанбаатар хотын өнөөгийн байдлыг тод томруунаар илтгэнэ.

Иймд ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ дэлхийн хөгжингүй хотуудын удирдлага, төлөвлөлтийн **туршлагыг** нийслэл хотод нутагшуулж, хотыг судалгаа, төлөвлөгөөнд тулгуурлан, **цомхон, чадварлаг, мэргэшсэн** багаар удирдах шийдлийг дэвшүүлж байна.

#### Цогц төлөвлөлттэй хот

1. Бид дотооддоо хот төлөвлөлтийг оновчтой хийх чадамжгүй нь нэгэнт нотлогдсон тул "чаддагаар нь хийлгэх" зарчмаар **хөгжингүй орны (Герман улсын) хот төлөвлөлтийг** нутагшуулан хэрэгжүүлнэ.
2. Хот төлөвлөлтийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй, орчин үеийн шийдлийг тусгасан, төсөв хөрөнгийн **зөв тооцоололтой** байх зарчмыг баримтлана.
3. Эдийн засаг, нийгмийн олон талт үр өгөөж бүхий **газар доорх** хотын төлөвлөлтийг төр, хувийн хэвшлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
4. Хотын төврүү чиглэсэн хэт төвлөрлийг задалж, хүн амын суурьшлын нягтралыг тэнцвэржүүлэх зорилгоор олон төв хотын тогтолцоог бий болгоно.
5. Улаанбаатар хотыг хөгжлийн хоёр дахь шат Мега хотын хэв шинж рүү хандаж байгааг хүлээн зөвшөөрч, аж үйлдвэрийн бүсүүдийг **салбар чиглэл бүрд** төлөвлөн, хүчирхэг цөм бүхий **дагуул хотуудаар** кластерчлан хөгжүүлнэ.
6. Дагуул хотыг худалдаа, үйлчилгээ, соёл, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлж, худалдаа, үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээ, тээвэр логистикийг шийднэ.
7. Олон төвт хотын төлөвлөлтийн хүрээнд Улаанбаатар хотыг хотын 2 төв, дэд 5 төв, олон нийтийн 26 төв, төрөлжсөн 4 төвтэй байхаар төлөвлөж, соёл, боловсрол, худалдаа, үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамжийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр бүтээн байгуулна.
8. Хотын **хуучин төвийн** өнгө төрхийг хэвээр хадгалж, сэргээн засварлах, хүчитгэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр тогтмол хийж гүйцэтгэнэ.
9. Хотын "Яармаг" **шинэ төвийг** үндэсний онцлогийг шингээсэн орчин үеийн архитектурын шийдэлтэй төлөвлөж, нийслэлийн бизнесийн төв болгон хөгжүүлнэ.
10. Хүн амын эрүүл орчинд амьдрах, байгаль орчин, экологийн хамгааллыг хангахын тулд хөгжлийн идэвхтэй бүс, хотын ногоон бүс, дагуул бүсийг оновчтой төлөвлөнө.
11. Төлөвлөлтгүй газар олголтыг бүрэн зогсоож, газар олгох үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгоно.



*M. Uyan*

12. Орчны болон орон зайн төлөвлөлт алдагдсан орон сууцны хорооллыг дахин төлөвлөнө.
13. Гэр хорооллыг эрс шинэчлэх дахин төлөвлөлтийн цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.
14. Нийслэл хотод шинээр баригдах барилга байгууламжийг хотын ерөнхий төлөвлөлтөд нийцсэн, өнгө төрхийг нэмсэн, орчныг цогцоор нь төлөвлөсөн, аюулгүй байдлыг бүрэн хангасан байхыг шаардана.
15. Хот төлөвлөлтийн бодлогыг саадгүй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн тогтолцоог бий болгоно.
16. Хот төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ нийслэлийн татварын зохицуулалтыг хөшүүрэг болгон ашиглана.


**Цомхон, чадварлаг засаглалтай хот**

1. Нийслэлийн засаглалыг дэлхийн хотуудын жишгээр **"Мэр"**-ийн тогтолцоонд шилжүүлнэ.
2. Хотын даргыг иргэд шууд сонгодог байх эрх зүйн шинэчлэл хийнэ.
3. Нийслэлийн засаглах болон гүйцэтгэх тогтолцоог салгаж, чадавхыг бэхжүүлнэ.
4. Нийслэл хот татвар, төсөв, санхүү, аж ахуйгаа **бие даан** удирдах эрх зүйн орчин бүрдүүлнэ.
5. Төсвийн үрэлгэн байдлыг халж, үр нөлөө өндөртэй төслүүдийг тэргүүнд **эрэмбэлэн** санхүүжүүлэх бодлого баримтална.
6. Нийслэлийн харьяа байгууллагуудын чиг үүргийн давхардал, хийдэл, үр дүнгүй, бүтээмжгүй байдалд дүн шинжилгээ хийж, **дахин загварчилна**.
7. Төрийн албыг мэргэжлийн, нээлттэй, хариуцлагатай, цомхон байх **зарчмыг** баримтлан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шинэчлэл хийж, улс төрийн намын коммунист тогтолцоог бүх түвшинд устгана.
8. Үр нөлөөтэй, хариуцлагатай, чадварлаг институцийг нийслэлийн захиргааны бүх шатанд бий болгоно.
9. Нийслэлийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн биржээр **хувьчлах** замаар төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хувьчлалаас олсон орлогыг баялгийн санд төвлөрүүлнэ.
10. Төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ.
11. Статистикийн чадавхыг бэхжүүлж, үнэн, бодит, цаг үеийн мэдээлэл, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, асуудал бэрхшээлийг урьдчилан харах, сэргийлэх, даван туулах чадвар бүхий ухаалаг засаглалд шилжинэ.
12. Нийслэлийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд **чадварт** суурилсан арга зүйг хэвшүүлж, чадвар, хандлага, ёс зүйг эрхэмлэнэ.
13. Төрийн үйлчилгээнд шинжлэх ухаанч, өөриймсөг, элгэмсэг **хандлагыг** суулгана.
14. Бүгд ижил жигд татвар төлдөг байх зарчмыг баримтлан татвар төлөгчдийн бааз суурийг өргөжүүлэх замаар нийслэлийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

**1.2. Оролцоог хангах цахим засаглалтай хот**

Ардчилал бол иргэдийн гарт засаглах эрхийг баттай атгуулсан байхын нэр билээ. Монголчууд бид өмнөх коммунист тогтолцооны "хүлцэнгүй байх" хүмүүжил, төлөвлөөс хагацаагүйн улмаас ардчилал өнөөг хүртэл амь ороогүй бөгөөд засаглах эрх иргэдэд

*А. Сүрэн*



бус улс төрийн намын удирдлагад, тэдний “угсарсан” шат, шатны бүлэглэлийн гарт бүрэн төвлөрчээ.

Иймд ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ нь ардчилалын үндэс болсон иргэдийн засаглах эрхийг орчин үеийн технологийн шийдлээр **иргэдийн гарт атгуулж**, намчирхлаас салгана.


**“Удирдлага”-аа ГАРТАА АВ**

1. Дүүрэг, хорооны шийдвэр гаргалтад иргэд **шууд** оролцох, санал өгөх, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх Цахим иргэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2. Цахим иргэнийг бүртгэх, баталгаажуулах, оролцоог нь хүлээн зөвшөөрөх механизм, зохицуулалтыг бүрдүүлж, иргэд өөрсдөө шийдвэр гаргадаг тогтолцоонд шилжинэ.
3. Бүтээн байгуулалтын ажлыг ач холбогдлоор эрэмбэлэх, төсвийг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхэд **цахим иргэдийн** саналыг харгалзах механизм бүрдүүлнэ.
4. Орон нутгийн засаг, захиргааны удирдлагад хариуцлага тооцож огцруулах талаар цахим иргэдийн санал тогтоосон босго тоог давсан тохиолдолд түүнийг огцруулах үндэслэлтэйд тооцох эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.
5. Нийслэлийн төсвийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
6. Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх төсөл, арга **хэмжээг цахим** иргэдийн саналыг харгалзан сонгон хэрэгжүүлдэг болно.
7. Санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангах шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна.
8. Иргэд төрийн цахим удирдлагыг гартаа авч, шийдвэр гаргалтад оролцоход тулгамддаг хууль, эрх зүйн зөрчлийг арилгаж, олон улсын жишигт нийцсэн цахим засаглалыг бэхжүүлнэ.
9. Орон нутгийн бодлого боловсруулахад иргэдийн дуу хоолойг тусгах зорилгоор олон нийтийн цахим хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулна.
10. Орон нутгийн засаг, захиргааны чиг үүрэгт хамаарах бүхий л чиглэлээр иргэн, хувийн хэвшлийн санал, санаачилгыг хүлээн авах “Үнэгүй алт” үндэсний аяныг өрнүүлж, иргэд, хувийн хэвшлийн саналыг ажил хэрэг болгох тогтолцоог бүрдүүлнэ.
11. Үнэгүй алт санаачилгын хүрээнд ажил хэрэг болсон саналыг өрсөлдөөний зарчмаар, нээлттэй, ил тодоор урамшуулахыг захиргааны журам, зохицуулалтаар дэмжинэ.

**Нэг цэгийн үйлчилгээнээс ЦАХИМ НЭГ ЦОНХ-ны үйлчилгээнд**

1. Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, хялбар, шуурхай, төвөггүй хүргэхийн тулд нэг цэгийн үйлчилгээг цахим нэг цонхны үйлчилгээнд шилжүүлнэ.
2. Цахим нэг цонхны үйлчилгээнд шилжих зорилтын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, харилцан мэдээлэл солилцох, мэдээлэл дамжуулах үйл явцыг нэг загвар, стандарт, журамтай болгох цогц ажлыг хийж гүйцэтгэнэ.
3. Төрийн үйлчилгээ, зөвшөөрөл олгох үйл явц, нийслэлийн худалдан авалтыг 100 хувь цахимжуулж, төрийн авилгалын эх үндсийг тасална.

*А. Согаал*



4. Төрийн үйлчилгээний цахимжилтад тулгуурлан нийслэлийн Их өгөгдлийг (big data) бүрдүүлж, хиймэл оюун ухаан (AI)-д суурилсан ухаалаг систем бүхий шийдвэр гаргалт, хяналтын системийг нэвтрүүлнэ.
5. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, нийслэлийн худалдан авалт, шийдвэр гаргалттай холбоотой мэдээллийг иргэдэд нээлттэй болгоно.
6. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажлын үр дүн, улирлын тайланг олон нийтэд тогтмол, нээлттэй мэдээлдэг болно.
7. Төрийн үйлчилгээ үзүүлэх цахим машины тоог нэмэгдүүлнэ.



*А. Сэрээт*



## 2. ЧАДДАГААР НЬ ХИЙЛГЭЭ



### 2.1. Суурь шийдэлтэй хот

Дэлхийн хамгийн хүйтэн нийслэлд хүн амын талаас илүү хувь нь суурьшиж, хэт төвлөрөл үүсгэн, дэд бүтцийн даацаа хэтрүүлсэн нийслэлд суурь шийдэл, дэд бүтцийн шинэчлэлт нэн шаардлагатай байна.

ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ дэд бүтцийн бүх асуудлыг төр дангаараа шийдэхээр оролддог бус төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан чаддагаар нь хийлгэх, сууриар нь шийдэх бодлогыг баримтлана.


#### Эрчим хүч, дулаан

1. Хотын хүн амыг найдвартай, тогтвортой эрчим хүч, дулаанаар хангах бодлого баримтлана.
2. Эрчим хүчний нийлүүлэлтийн найдвартай, тогтвортой байдлыг хангахын тулд Төвийн бүсийн эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, цахилгааны шугам сүлжээг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
3. Цахилгаан станцуудад бүрэн шаталттай, ашигт үйлийн итгэлцүүр өндөртэй технологийг нэвтрүүлнэ.
4. Цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээний алдагдлыг бууруулна.
5. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ, худалдааг тууштай дэмжиж, эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлнэ.
6. Нийслэлийн гэр хорооллын болон зуслангийн бүсийн гэрэл цахилгаангүй, хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангаж, цахилгаан эрчим хүчний хангалтыг 100%-д хүргэнэ.
7. Дулааны эх үүсвэрүүдийг өргөтгөх, шинэ эх үүсвэр төлөвлөх, шугам сүлжээг шинэчлэх, техник, технологийн шинэчлэлт хийх бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийж гүйцэтгэнэ.
8. Дамбадаржаа, Дэнжийн мянгын дэд төвүүдэд дулааны станц шинээр барьж ашиглалтад оруулна.
9. Дулааны гол магистраль шугамын дулаан нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.
10. Бие даасан дулааны эх үүсвэрийн бүтээн байгуулалтыг дэмжинэ.




#### Ус хангамж, ариутгах татуурга

1. Нөхөн сэргээгдэх гадаргын усны эх үүсвэрээс нийслэлийн хүн амыг унд – ахуйн усаар хангах, нийслэл ундны усны нөөцийг нэмэгдүүлэх “Туул усан цогцолбор” төсөл хэрэгжүүлэхийг дэмжиж, ашиглалтад оруулна.
2. Ундны усны эх үүсвэрийн гүний худгийг тоолууржуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
3. Ус ашиглалтын үр ашгийг бүх салбарт дээшлүүлж, устай холбоотой экологийн тогтолцоог хамгаална.




*A. Сүхбаатар*

4. Гол, горхи, булаг, рашаан, нуур, тойромд усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс тогтоох судалгаа хийж, усны нөөц доройтон хомсдож, бохирдох аюул учирч байгаа нийслэлийн хэмжээний ач холбогдол бүхий усны эх үүсвэрийг орон нутгийн хамгаалалтад авна.
5. Булаг шандын эхийг тохижуулан хамгаална.
6. Зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулна. Нийслэлийн нийт өрхөд зөөврийн ус хэрэглэдэг өрхийн эзлэх хувийг бууруулна.
7. Усны бохирдлыг багасгах, химийн хорт бодис, бохир хаягдал, материалд голт цутгах явдлыг зогсоох, ундны ус, ариун цэврийн байгууламжийн менежментийг сайжруулахад ард иргэдийн дэмжлэг, оролцоог нэмэгдүүлнэ.
8. Бохир усыг дахин боловсруулах, ашиглах замаар саарал усны ашиглалтыг нэмэгдүүлэхийг татварын бодлогоор дэмжинэ.
9. Үйлдвэрийн хаягдал усны хяналтын системийг сайжруулна.
10. Улаанбаатар хотын шинэ цэвэрлэх байгууламжийн төслийг дэмжиж, бүтээн байгуулалтын ажлыг дуусган ашиглалтад оруулна.
11. Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг чиглүүлнэ.
12. Ариутгах татуургын хүчн чадлыг нэмэгдүүлэх төслүүдийг дэмжиж, ашиглалтад оруулна.
13. Лаг зайлуулах ба боловсруулах судалгаа хийж, лагийн менежментийн урт хугацааны төлөвлөгөө боловсруулна.




### Орон сууц

1. “Орон сууцны стратеги төлөвлөгөө”, “Нийслэлийн орон сууцны фонд”-оос санхүүжих нөхцөл сайтай Түрээсийн орон сууцны цогц хөтөлбөр, төлөвлөгөөг эрх зүйн зохицуулалтын хамт шинэчлэн боловсруулан хэрэгжүүлнэ.
2. Нийслэлийн иргэдийг орон сууцжуулах төлөвлөлтийн хүрээнд бодит үнэтэй орон сууцны нийлүүлэлтийг хөхиүлэн дэмжиж, ипотекийн зээлийг эзэнд нь хүргэх, зээлийн хүүг бууруулах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
3. Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан түрээсээс өмчлөх санаачилгыг хэрэгжүүлнэ.
4. Ахмадууд тэтгэвэрт гараад амар тайван аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, боломжийн үнэтэй, талбай багатай, худалдаа үйлчилгээ нь ойрхон Ахмадын орон сууцны хүртээмжийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр бий болгоно.
5. Барилга, барилгын материал үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжиж хөгжүүлнэ.
6. Барилгын чанар, стандартад нийцэхгүй, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дахин төлөвлөлтөд хамруулна.



### 2.2. Хүртээмжтэй хот

Улс төр, эдийн засгийн хулгайгаас болж иргэдийн боловсрол, эрүүл мэнд, амьдралын чанар доройтлоо. Хүнийг төрийн бодлогын төвд байлгахыг лоозогнодог ч төрийн бодлогын төвд хүн бус “улс төрчдийн бизнес” байсаар ирлээ. Үр дүнд нь Монгол хүний үнэ цэн, өрсөлдөх чадвар унаж, нийгэм бүхэлдээ хохирлоо.



*S. Bayar*



ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ үүнийг өөрчилж, хүндээ хүртээмжтэй нийгмийн бодлогыг, бүх үйлчилгээ ойр байх цогц шийдлийг санал болгоно.


**Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр**

1. Нийслэлийн боловсролын үйлчилгээ ачаалалтай, хүртээмжгүй байгаа нь боловсролын барилга байгууламжийн дутагдлаас үүдэлтэй тул хувийн хэвшлийн хэрэгжүүлж буй боловсролын зориулалттай барилга байгууламжийн төслийг дэмжинэ.
2. Сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлж, нийслэл хотод жил бүр 25 цэцэрлэг шинээр барьж ашиглалтад оруулан, түрээсийн байртай цэцэрлэгийн тоог тэглэнэ.
3. Ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлж, нийслэл хотод жил бүр 15 сургууль барьж ашиглалтад оруулан, түрээсийн байртай сургуулийн тоог тэглэж, барилга ашиглалтын коэффициентийг бууруулна.
4. Цэцэрлэг, сургуулийн барилга шинээр барьж, өргөтгөл хийснээр хамран сургалтыг зорилтот түвшинд хүргэж, 3 ээлжээр хичээллэдэг сургуулийн тоог тэглэнэ.
5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад их засвар, дотоод тохижилт хийж, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэн сургалтын орчныг сайжруулна.
6. Ерөнхий боловсролын сургуулиудын байгалийн ухаан, мэдээллийн технологийн сургалтын чанарыг сайжруулахад зориулж шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг төр, олон улсын байгууллагын хамтын ажиллагаагаар хэрэгжүүлнэ.
7. Ерөнхий боловсролын сургуулиудад англи хэлний сургалтын чанарыг сайжруулах хөтөлбөрийг олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.
8. Сургалтын цахим платформ, цахим сургалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжиж, хэрэглээнд нэвтрүүлнэ. Интерактив цахим хичээл явуулах боломж бүрдүүлсэн ЕБС-ийн тоог нэмэгдүүлнэ.
9. Насан туршийн боловсролд зориулсан контентыг нэмэгдүүлж, олон нийтэд хүргэнэ.
10. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрөөс үзүүлэх боловсролын зарим үйлчилгээг иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ.

**Эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр**

1. Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ.
2. Нийслэлд төрөлжсөн эмчилгээний төвүүдийг шинээр барьж, ашиглалтад оруулна.
3. Дүүргийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг шинээр байгуулж, нийслэлийн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, өвчлөлөөс сэргийлэх, үзлэг, оношилгооны хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
4. Дүүргийн эрүүл мэндийн төвийг түшиглэн дүүрэг бүрт Эрэгтэйчүүдийн кабинетийг шинээр байгуулна.







5. Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын их завсар, дотоод тохижилт, нэн шаардлагатай болон орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтэнэ.
6. Жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ. Өрхийн эрүүл мэндийн төвийн тоог 200-д хүргэнэ.
7. Хотын хүн амыг аюулгүй, үр дүнтэй, нэн хэрэгцээт эм, вакцинаар хангаж, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.
8. Эрт илрүүлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх нөлөөллийн аяныг эрчимжүүлж, хамрагдалтын түвшинг зорилтот хувьд хүргэнэ.
9. Товлолт болон товлолт бус дархлаажуулалтын хамрагдалтын түвшинг зорилтот түвшинд хүргэнэ.
10. Нийслэлийн Түргэн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд бүрэн тоноглогдсон автомашины хангалтыг нэмэгдүүлнэ
11. Агаарын түргэн тусламжийн тогтолцоог төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгож, яаралтай тусламжийг олон улсын зэрэглэлд хүргэнэ.
12. Нийслэлийн эрүүл мэндийн санхүүжилтийг нэмэгдүүлж, салбарын боловсон хүчний тогтвор, суурьшил, чадавхыг сайжруулж, ажиллах хүчний хомсдолд орохоос сэргийлнэ.

**Спорт, соёл, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр**

1. Спортын барилга, байгууламж барьж, ашиглалтад оруулсан хувийн хэвшлийг татварын бодлогоор дэмжинэ.
2. Спорт цогцолборгүй дүүрэг, хотын дэд төвүүдэд шинээр спорт цогцолборын барилга барьж ашиглалтад оруулна.
3. Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир, спортын талбайг иж бүрэн тохижуулна.
4. Хүүхэд, залуучуудыг багийн спортоор хичээллэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, спортыг дэмжих зорилгоор дүүрэг бүрт хөлбөмбөгийн стандартын талбай, хороо бүрт 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулна.
5. Хүүхдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх, сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хичээлээс гадуурх сургалт, сонгон, секц дугуйлан e-STEM HUB, e-СПОРТ, e-УРЛАГ үйлчилгээгээр дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулна.
6. Дүүрэг бүрт томоохон цэцэрлэгт хүрээлэн байгуулж, хороо бүрт амралт, зугаалгын бичил орчинг тохижуулна.
7. Нийтийг хамарсан биеийн тамирын томоохон арга хэмжээнүүд зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
8. Түүхийн дурсгалт барилга, байгууламжуудыг сэргээн засварлаж, аялалын үзмэр болгох бодлогыг хэрэгжүүлнэ.
9. Нийслэлийн соёл, урлагийн байгууллагуудад засвар үйлчилгээ хийж, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулна.
10. Хотын соёлын цуврал контентийн тоог нэмэгдүүлнэ.



*А. Сүхбаатар*

### 2.3. Тааламжтай орчинтой хот

Нийслэлийн иргэд бухимдалтай байна. Өвөлдөө утаанд, зундаа усанд автаж, тог цахилгаан, халуун усаа хязгаарлуулж, замын хөдөлгөөн тэг зогсож, нялхас цэцэрлэггүй, хүүхэд сургуульгүй, иргэд эрүүл мэндийн үйлчилгээгүй, ахмад халамжгүй, бүх нийтээрээ ая тухгүй, сэтгэл ханамжгүй байна. Үүний учиг нь төсвийн хулгай, хяналтгүй зарцуулалт, чаддаг нь бус эрх мэдэлтэй нь тендер авч, төрийн мөнгийг бүлэглэн шамшигдуулдаг намчингуудын шунал юм.

Иймд ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ түгжрэлгүй, утаагүй, хоггүй, бохирдолгүй, аюулгүй, амар тайван, аятай тухтай, гамшигт тэсвэртэй хотын шийдлийг санал болгож байна.

#### Түгжрэлгүй хотын шийдэл

1. Нийслэлийн авто замын сүлжээг өргөтгөх бодлогын хүрээнд гол авто зам болон тусламж гудамж замууд, гүүрэн байгууламж, нүхэн гарц, тойрог зам, олон түвшний огтлолцол бүхий замуудыг хотын төлөвлөлтийн бодлоготой уялдуулан барьж ашиглалтад оруулна.
2. Авто замын бүтээн байгуулалтад зориулж газар чөлөөлөлтийг хууль эрх зүйн хүрээнд хийж гүйцэтгэнэ.
3. Нийслэлд автомашины дугаарын хязгаарлалттай зорчих зохицуулалтыг цуцалж, иргэдийн хувийн өмчөө бүрэн ашиглах эрхийг нээнэ.
4. Түгжрэлийг бууруулж ажил, амьдралын тэнцвэр, зохистой харьцааг бий болгохын тулд боломжтой салбарт зайнаас ажиллах сонголт, уян хатан ажлын цагийн системийг дэмжих нөхцөлийг бүрдүүлнэ. Нийслэлийн захиргааны байгууллагуудыг ажлын цагийн уян хатан зохицуулалтад шилжүүлнэ.
5. Олон төрлийн нийтийн тээврийн үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
6. Нийтийн тээврийг сайжруулах ажлын хүрээнд нийтийн тээврийн маршрут төлөвлөлтийг шинэчилнэ. Нийтийн тээврийн ерөнхий системийг өртөөчилсөн тойрог хэлбэрийн хөдөлгөөнд шилжүүлнэ.
7. Нийтийн тээврийн үндсэн сүлжээтэй холбосон богино эргэлтийн маршрутуудыг шинээр бий болгож, дундын болон эцсийн зогсоолыг оновчтой төлөвлөнө.
8. Нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлийг үргэлжлүүлж, нийтийн тээврийн шинэчлэл хийснээр нийтийн тээврээр үйлчлүүлэх зорчигчийн тоог нэмэгдүүлнэ.
9. Замын хөдөлгөөний удирдлагын зохион байгуулалтын ухаалаг системийг бүрэн нэвтрүүлнэ.
10. Авто замын хөдөлгөөн зохицуулалт, зөрчил илрүүлэх камер, тоног төхөөрөмжийн ашиглалтыг нэмэгдүүлж, замын хөдөлгөөнд хяналт тавих нөхцөлийг сайжруулна.
11. Ачаалал өндөртэй уулзваруудад дахин инженерчлэл хийнэ.
12. Хотын төвүүдэд их багтаамжийн давхар зогсоол байгуулна.
13. Зорчих хөдөлгөөнд саад учруулж буй хашаа, хайс, саадыг буулгах ажлыг тогтмол хэрэгжүүлнэ.
14. Замын хөдөлгөөний хэвийн урсгалыг сааруулж буй авто замын хагарал, эвдрэлийг шуурхай мэдээлэх систем хөгжүүлж, иргэдийн мэдээлэл босго тоог давсан тохиолдолд нэн даруй засварладаг болох механизм бүрдүүлнэ.
15. Явган болон дугуйн замыг өргөжүүлж, дугуйн зогсоол байгуулж, автомашины хэрэглээг бууруулах замаар түгжрэлд нөлөөлнө.



*А. Сэрэн*

**Утаагүй хотын шийдэл**

1. Гэр хорооллыг орон сууцжуулах цогц хөтөлбөр хэрэгжүүлж, яндангийн тоог бууруулна.
2. Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг урамшуулж, таниулан сурталчлах арга хэмжээ хэрэгжүүлнэ.
3. Хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн стандарт, норм дүрэм, эрх зүйн орчин бүрдүүлнэ.
4. Бие даасан халаалтын зуухыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг эрчимжүүлнэ.
5. Сайжруулсан шахмал түлшний хэрэглээг дэмжих санаачилгыг үргэлжлүүлж, сайжруулсан түлшний нөөц бүрдүүлэх, борлуулалтын цэгийг нэмэгдүүлэх, худалдаа, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой төлөвлөнө.
6. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лаборатори шинээр байгуулан сайжруулсан түлшний үйлдвэрлэлд тавих хяналтыг сайжруулна.
7. Цахилгаан болон хийн түлшээр ажилладаг суудлын автомашин, нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
8. Автозамын хөдөлгөөнд оролцож буй дизель хөдөлгүүрт нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох хяналтыг чангаруулна.
9. Агаар орчны чанарын хяналт шинжилгээний чадавхыг олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр сайжруулна.

**Хоггүй хотын шийдэл**

1. Нийслэлийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
2. Хог хаягдалгүй, бохирдол бага ялгаруулах хэрэглээг дэмжиж, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах дэвшилтэт технологи, шийдэл бүхий хувийн хэвшлийн төслийг дэмжиж, хамтран ажиллана.
3. Нийтийн эзэмшлийн талбайд байрших хогийн савны тоог нэмэгдүүлнэ.
4. Хог тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хуваарийн дагуу үйлчилдэг болгоно.
5. Хог тээврийн байгууллагад авто машины парк шинэчлэлт хийнэ.
6. Шинээр барьж буй хотхон, хорооллын хог хаягдлыг ангилан ялгаж, хог хаягдлын автоматаар татан авах технологийг нэвтрүүлнэ.
7. Хог хаягдал дарж булсан ландфилын нөхөн сэргээлтийн талбайг нэмэгдүүлнэ.
8. Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах, бордоо үйлдвэрлэх төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
9. Ахуйн хэрэглээний болон цахилгаан станцаас гарах үнс, лаг хог хаягдлыг дахин ашиглаж, хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болно.
10. Хог хаягдлыг ангилсан, ялгасан, бууруулсан, дахин ашигласан аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих, урамшуулах, газрын төлбөр болон татвараас чөлөөлөх эрх зүйн орчин бүрдүүлнэ.



*Handwritten signature*

**Бохирдолгүй хотын шийдэл**

1. Хотын орчны бохирдлын менежментийг сайжруулах төслийг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
2. Айл өрхийн нүхэн жорлонг шинэчлэн, стандартад нийцүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, шаардлага хангасан айл өрхийг урамшуулах механизм бүрдүүлнэ.
3. Олон нийтийн газар байрлах нийтийн бие засах газрын тоог нэмэгдүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
4. Орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалт, үйлчилгээний салбарын машин, механизм, төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.
5. Хөрсний нянгийн болон хүнд металлын бохирдлыг бууруулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
6. Хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.
7. Хөрсний доройтлын судалгаа хийж, хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.



**Аюулгүй, амар тайван хотын шийдэл**

1. Нийслэлд гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгддэг гудамж зам талбай эмзэг цэгүүдийг камержуулах, удирдлагын төвд холбох ажлыг хэрэгжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, олж илрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Хороо, хэсгийн цагдаагийн хэсэг, ажилчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай техник хэрэгслээр хангана.
3. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийн цагдаа арга хэмжээг үргэлжлүүлэх
4. Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн барилгыг шинээр барих ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.



**Ая тухтай орчинтой шийдэл**

1. Хотын нэгдсэн стандарттай болж, стандартыг мөрдүүлэх ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулна.
2. Хотын хаягжилтын шинэчлэлийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
3. Гэр хорооллын бүсийн хороо бүрт амарч зугаалах орчин бүрдүүлсэн бичил тохижуулалт хийнэ.
4. Иргэдийн ая тухтай алхаж явах орчныг бүрдүүлэх үүднээс явган хүний зам болон дугуйн замын хүртээмжийг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн чанарт анхаарч ажиллана.
5. Гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж нэгдсэн удирдлагад холбоно.
6. Авто зогсоолыг нэмэгдүүлэхэд анхаарч, барилга байгууламжийн зориулалтаас хамааран тогтоосон тоо хэмжээний зогсоол барих шаардлагыг мөрдүүлнэ.
7. Олон нийтийн үйлчилгээ төвлөрсөн газруудын ойролцоо тусгай зориулалтын, стандартад нийцсэн дугуйн зогсоолууд байгуулна.
8. Дугуй, сүүтэр түрээслэх үйлчилгээний хүртээмжийг хувийн хэвшилд тулгуурлан хөгжүүлэхийг дэмжинэ.
9. Зөвшөөрөлгүй баригдсан грашийг буулгаж, тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийнэ.



*Handwritten signature*

10. Хот доторх автомашины зогсоолыг давхар зогсоолоор шийдэхээс гадна орон сууцны хороолол доторх автомашины зогсоолыг шийдвэрлэнэ.


**Гамшигт тэсвэртэй хотын шийдэл**

1. Нийслэл хотын гамшгийн эрсдэлийг бууруулах цогц менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.
2. Гамшгийн эрсдэлээс сэргийлж, барилга байгууламжийн чанар, насжилтыг тодорхойлох, болзошгүй аюул, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, паспортжуулах, эрсдэлтэй барилга, байгууламжийг хүчитгэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
3. Гамшгийн үед түр хоргодох байрыг стандартын шаардлага хангасан хэмжээнд бэлдэж, бэлэн байлгах эрх зүйн зхицуулалтыг хийнэ.
4. Инженерийн бэлтгэл ажлын мастер төлөвлөгөөний хүрээнд үерийн эрсдэлээс сэргийлж голуудын үерийн хамгаалалтын далан, үерийн хамгаалалтын суваг, зам талбайн ус зайлуулах шугам сүлжээ, ул хөрсний ус доошлуулах шугам сүлжээг жил бүр тодорхой төлөвлөгөөт ажлын хүрээнд засаж, сайжруулна.
5. Ойн түймрээс хамгаалах халз зурвас сэргээх ажлыг хэрэгжүүлнэ.
6. Гал түймэр унтраах, аврах ангийн тоог нэмэгдүүлнэ.
7. Гамшигтай тэмцэх, гал түймэр унтраах автомашины тоог нэмэгдүүлэх, техник, багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлнэ.
8. Түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх, нэвтрэх боломжийг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

**2.4. Иргэндээ ээлтэй хот**

**Хүүхдэд ээлтэй хот**

1. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.
2. Бага насны хүүхдийн эрүүл мэндийн хяналтыг цахимжуулж, шаардлагатай эмчилгээ, үйлчилгээний хүртээмжийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр оновчтой зохион байгуулна.
3. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, Цалинтай ээж хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4. Цэцэрлэг, сургуулийн бүртгэл, элсэлтийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сугалааг хална.
5. Хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд сургуулийн байр, дотоод орчныг суралцагчдын онцлогт нийцүүлэн тохижуулж, олон улсын стандартад нийцүүлнэ.
6. Цэцэрлэг, сургуулийн орчинг камержуулж, хүүхдийн эрхийн зөрчилд хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.
7. Хүүхдэд зориулсан танин мэдэхүйн музей байгуулна.
8. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нөлөөллийн олон талт арга хэмжээ зохион байгуулна.




*А. Сүхбаатар*

9. Сургуулиас гэр, гэрээс сургууль хүртэлх замд хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.
10. Хүүхдийг зам тээврийн ослоос сэргийлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.
11. Шаардлага хангасан сургуулийн болон хүүхдийн автобусаар хүүхдэд үйлчлэх санаачилгыг дэмжиж, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтлана.
12. Хүүхдийн хөгжлийн төвүүд байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

#### **Залууст ээлтэй хот**

1. Залуусын амьдралын эрүүл хэв маягийг бүрдүүлэх зорилгоор бие бялдраа хөгжүүлэх, спортоор хичээллэх орчинг бий болгоно.
2. Залуус биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгох, мансууруулах бодис, тамхи, архины хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, эмчлэх үйлчилгээг сайжруулна.
3. Залуу үеийнхэнд санхүүгийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, хөрөнгө оруулалтын Санхүүгийн авдар цахим систем, үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэвтрүүлнэ.
4. Хүрээлэн буй орчныг хамгаалах төслүүдэд сайн дураараа ажиллах боломжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд цахим тогтолцоогоор хэрэгжүүлнэ.
5. Шинжлэх ухаан, технологи, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлж, үеийнхний ур чадварыг дээшлүүлэх, дадлага хийх боломж олгох, бодит туршлана олж авах, ирээдүйн карьерт нь бэлтгэх Дөрөө системийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.




#### **Ахмадад ээлтэй хот**

1. Ахмадын эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг байршлаас үл хамааран хүртээмжтэй болгох цахим тогтолцоог төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
2. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хагас болон бүтэн цагаар уян хатан нөхцөлөөр ажиллах боломжийг бүрдүүлнэ.
3. Ахмадуудад өөрсдийн тэтгэврийн хуримтлалыг удирдах, хөрөнгө оруулалт хийх, өгөөж хүртдэг байх, санхүүгийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.
4. Ахмадын нийгмийн оролцоо, хувь хүний хөгжлийг дэмжих Аз жаргалтай ахмадууд цогц санаачилгыг хэрэгжүүлнэ.



#### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хот**

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөх гэгээрлийн ажлыг тэдэнтэй хамтран хэрэгжүүлнэ.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, эрхийн зөрчлийн талаарх мэдээллийг цаг тухайд нь хүлээн авах механизмыг бий болгоно.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн үйлчилгээг биечлэн очиж авдаг системийг халж, цахим хэлбэрт шилжүүлнэ.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажилд авч буй бизнес эрхлэгчдийг урамшуулах, хувиараа хөдөлмөр эрхлэх санаачилгыг



*Handwritten signature*

дэмжих, ур чадварыг хөгжүүлэх сургалтыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, тогтмолжуулна.

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлсан эмнэлэгийн тусламж үйлчилгээг бий болгоно.
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан нийтийн эзэмшлийн талбайд аюулгүй нэвтрэх дэд бүтцийг бүрдүүлж, төсвийн тодорхой хувийг зарцуулахаар хуульчилна.
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлсан тээврийн хэрэгслийн нийлүүлэлтийг бий болгох аж ахуйн нэгжийн санаачилгыг дэмжинэ.
8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлсан боловсролын үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжинэ.



*J. Vozen*





### 3. ХОТЛООРОО БАЯЖЬЯ


#### 3.1. Бизнесийг дэмждэг хот

Монгол Улсад зах зээлийн эдийн засаг бүрэлдэн тогтсонгүй, төр бизнесээс савраа татсангүй. Улаанбаатар хот төсвийн орлогын 80%-ийг татварын орлогоор, татварын орлогын 95%-ийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар бүрдүүлдэгч бизнес эрхлэгчдээ дэмжих бус хянах, хязгаарлах, дарамтлах бодлого явуулж ирлээ. Зөв зүй тогтлоороо бол улс төрчид, хувийн хэвшлийнхэн эдийн засгаа хүчирхэгжүүлэхийн төлөө эмээлийн хоёр бүүрэг лугаа хамтрагчид байх ёстой.

Тиймд ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ төсвийн орлогыг бүрдүүлэгч бизнес эрхлэгчдийг төрийн дарамтаас салгах, бизнесээ чөлөөтэй эрхлэх, төрийн хяналтыг эрсдэлийг онилох хэлбэрээр явуулах, хувийн хэвшилд эрх чөлөөг олгох зарчмыг баримтлана.



#### Төр бизнест оролцохгүй байх зарчмын хүрээнд

1. Бизнесийн байгууллагууд хийх боломжтой ажлыг төрөөс бизнест шилжүүлэх, аутсорсинг хийх замаар бизнес дэх төрийн оролцоог тэглэнэ.
2. Төр хувийн хэвшилтэй бизнесийн талбарт өрсөлдөхгүй.
3. Бизнесийн, төрийн бус байгууллагын хийж чадах болон чадаж буй ажлыг төр хийхгүй.
4. Төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд эрсдэлийн менежментийг нэвтрүүлнэ.
5. Төр зөвхөн үндэсний аюулгүй байдал, хууль бус өрсөлдөөн, зах зээлийн давамгай байдлыг зохицуулах хүрээнд бизнесийг зохицуулна.



#### Төрөөс бизнесийг дэмжих зорилтын хүрээнд

1. Нэр хүнд бүхий олон улсын санхүүгийн байгууллага болон түүний салбар нэгжийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх замаар бага өртөгтэй, урт хугацаатай санхүүжилтийн эх үүсвэрийг татаж, түүнийг бизнесийн санхүүжилтэд зориулна.
2. Бизнес эрхлэгчид эрсдэлээс айхгүйгээр бизнесээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор даатгалын салбарыг хөгжүүлнэ.
3. Хариуцлагын даатгалын тогтолцоо нэвтрүүлэхийг дэмжиж, төрийн болон хувийн хэвшлийн хяналтын үүргийг даатгалын салбараар гүйцэтгүүлж, чанаргүй ажил, үйлчилгээнээс бусдад учруулсан хохирлыг даатгалын компани хариуцах тогтолцоог бүрдүүлнэ.
4. Баталгааны даатгалыг хөгжүүлж, тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа, чанарын баталгаа байдлаар их хэмжээний мөнгийг банканд түгжиж, эдийн засгийн эргэлтэд орох боломжийг хаадаг байдлыг хална.
5. Томоохон аж ахуйн нэгж, байгууллагын болон төрийн худалдан авалтыг гэр бүл төвтэй бизнесээс нийлүүлэхийг тогтмол дэмжиж, чанар стандартад нийцэх, технологийн сургалтуудыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.



*Handwritten signature*

### 3.2. Орлоготой иргэнтэй хот

Эдийн засгийн зогсонги байдал, төгрөгийн ханшийн уналт, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт зэрэг хавсрага шалтгааны улмаас хотын иргэдийн цалин, тэтгэвэрийн орлого хаанаа ч хүрэлцэхгүй байна. Ажил хийгээд ч авч буй цалин сарын зардалдаа хүрэхгүй тул цалин орлогоо барьцаалж, өрөнд баглуулж байна. Монголд зээлгүй, санхүүгийн дарамтгүй хүн улс төрчдөөс өөр байхгүй. Өртэй хүн өлмий дор билээ.

Иймээс ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ-ээс бүх иргэд нь орлоготой, ажил хөдөлмөр эрхэлдэг байх бодлогыг хэрэгжүүлнэ.



#### Бизнес эрхлэгчдээ дэмжих арга хэмжээ

1. Бизнесд ээлтэй орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд бизнесийг зохицуулсан дүрэм журмыг тодорхой болгож, бүгдэд ижил тэгш үйлчилдэг байх зарчмыг мөрдүүлнэ.
2. Төрийн хяналт, татварын дарамт, шахалтыг багасган, байгууллагын дансыг хаадаг үйл ажиллагааг зогсооно. Төр нь хувийн хэвшлийг дэмждэг, үйл ажиллагаа хэвийн явуулахад нь саад болдоггүй байх системийг бий болгоно.
3. Төрийн хяналтыг эрсдэлд суурилсан зарчмаар хэрэгжүүлж, бүгдийг бус зөвхөн эрсдэлтэйг хянах, шаардлага тавих менежментэд шилжинэ.
4. Ажлын байр бий болгох, хадгалах, бичил болон гарааны бизнес эхлүүлэх, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, сэргээхэд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
5. Нийслэлийн худалдан авах ажиллагааг дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжихэд чиглүүлнэ.
6. Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд онцгой анхаарч бодлогоор дэмжин, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд санхүү, борлуулалт, хүний нөөц, ажлын байр, үйлдвэрлэл зэрэгт зөвлөгөө өгч, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын оролцоотойгоор тодорхой дэмжлэг үзүүлнэ.
7. Инновац нэвтрүүлэх, бизнес эрхлэх, ажлын байр бий болгоход чиглэсэн жижиг, дунд бизнес, гарааны бизнес эрхлэгчдэд болон банкны зээлийн босго давахгүй иргэдэд зорилтот зээлийн хүртээмжийг сайжруулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үзүүлнэ.
8. Нийслэл, дүүргүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвүүдийн үйл ажиллагааг сайжруулж, жижиг, дунд үйлдвэрлэгчдэд бодитой дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгоно.

#### Бизнестэй иргэн – Бүртгүүлээд шууд эхэл.

1. Элдэв төрлийн шаардлага, зөвшөөрөл, эрх мэдлээр далайлгаж, бизнес эрхлэх боломжийг хаадаг байдлаас салгаж, бүртгүүлээд бизнесээ шууд эхлүүлэх боломжийг олгоно.
2. Бизнес эрхлэгч, эрхлэхийг эрмэлзэгч иргэдэд хандсан бизнес эрхлэлтийг дэмжих “баяж” экосистемийг бүрдүүлнэ. Баяж экосистемийн хүрээнд бизнесийн зөвлөгөө, санхүүжилт, бойжуулалтын цогц арга хэмжээ хэрэгжүүлж, энэ ажилд төр, олон улсын байгууллагын дэмжлэгийг чиглүүлнэ.
3. Залуусын ажлын байран дахь хөдөлмөрийн бүтээмжийн үнэлгээг бодитой, шударга болгоно.

*J. Согоо*



4. Тэтгэвэрийн нас нь ойртож буй идэр настангуудад тэтгэвэр тэтгэмж, хөрөнгө оруулалтын стратегийг удирдах арга, мэдлэг мэдээллээр хангах, хуримтлал үүсгэх төлөвлөлт, зөвөлгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлнэ.
5. Ахмадын санхүүгийн баталгааг хангах, хуримтлалаараа хөрөнгө оруулалт хийх боломжтой, өв залгамжлуулдаг, тэтгэвэрийн хэмжээ нь жил бүр нэмэгддэг, тэтгэвэрийн гурван давхаргат тогтолцоонд шилжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
6. Гудамжны худалдаа эрхэлдэг хувь хүмүүст худалдаа, бизнесээ явуулах боломжит газруудыг заан өгч, нэгдсэн бүртгэлтэй болгон эрүүл ахуйн шаардлагыг сахих, стандарт, үйлчилгээний соёлыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой бодлого хэрэгжүүлнэ.



### 3.3. Хотын бизнесийн тэргүүлэх чиглэлүүд

Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг 3772 аж ахуйн нэгж хамрагдсан бизнесийн орчныг үнэлгээгээр дундаас доогуур түвшинд үнэлэгдэж, 2020 оноос 8 хувиар буурсан байна. Төрийн байгууллагаас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд бизнест дэмжлэг харьцангуй бага нөлөө үзүүлжээ. Улаанбаатар хотын бизнес эрхлэгчид бизнесийн орчныг сайжруулахад зээлийн хүүг бууруулан нөхцлийг сайжруулах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, үндэсний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих, авилга, хүнд суртлыг бууруулахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай гэж үзсэн байна.

Иймээс ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ-ээс төр бизнест дарамт шахалт үзүүлдэг, төр бизнес хийдэг, төрийн оролцоо, хүнд суртал үзүүлдэг байдлыг устгаж, хотын бизнесийн тэргүүлэх чиглэлүүдэд бодлогын түвшинд дэмжиж ажиллана.

#### Хүнс үйлдвэрлэл


1. “Хүнсний хангамж - Үндэсний аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн өрнүүлж, хүнсний боловсруулах үйлдвэрүүдийг шинэчлэх, хүнсний түүхий эдийн байршил, нөөц, хангамжид тулгуурлан шинээр байгуулах, нэмүү өртөг шингээх иж бүрэн стратеги хэрэгжүүлнэ.
2. Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.
3. Нийслэлийн иргэдийн гурил, төмс, гол нэрийн хүнсний ногооны хэрэглээг үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.
4. Хот орчимд эрчимжүүлсэн мал аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж өндөр үр ашигтай малын тоо толгойг нэмэгдүүлэн нийслэл хотын хүн амыг суу, шинэ мах, өндгөөр хангана.
5. Эрүүл ахуйн стандарт хангасан хүнсний бүтээгдэхүүний агуулах, зоорийн цогцолбор байгуулна.
6. Органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.



#### Хөдөө аж ахуй

1. Нийслэл хотын баруун болон, зүүн бүсэд мах боловсруулах үйлдвэр байгуулна.
2. Үйлдвэрийн аргаар бэлтгэж боловсруулсан нөөцийн махны үйлдвэрлэлд хяналт тавьж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулна.

*Handwritten signature*



3. Газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид тариалалт хийх хүнсний ногооны үр олгоно.
4. Алтан намар, намрын ногоон өдрүүд арга хэмжээний хүрээнд эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг зохион байгуулна.
5. Түүхий эдийн нөөц ашиглалтыг сайжруулж, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулна.
6. Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйн үйлчилгээг тохирлын үнэлгээнд үе шаттай хамруулна.
7. Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний шинжилгээ хийж, баталгаажуулалт олгоно.

#### **Хөнгөн үйлдвэрлэл**

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Цагаан алт санаачилгыг дэмжиж, ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих цогц тогтолцоог хэрэгжүүлнэ.
2. Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг борлуулах худалдааны нэгдсэн тогтолцоо үүсгэнэ.
3. Судалгаа хөгжүүлэлт, инновац болон байгаль орчинд ээлтэй шинэ технологи ашиглан, арьс ширийг шинэлэг тогтолцоо бүхий бэлтгэн нийлүүлэлттэй кластер үйлдвэрлэлээр боловсруулах ажлыг дэмжиж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.



#### **Аялал жуулчлал**

1. “Улаанбаатарт тавтай морил” нэртэй гадаадын жуулчдад зориулсан хөтөлбөрийг санаачилж, ажлын хүрээнд бэлэг дурсгалын брэнд бүтээгдэхүүнүүдийг үндэсний үйлдвэрлэгчидтэй гэрээ байгуулж дэмжин ажиллана.
2. Монголын уламжлалт баяр наадам, түүх соёлын өвд тулгуурласан аялалын бүтээгдэхүүн хөгжүүлэх, эвент арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамран ажиллана.
3. Соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлээр идэвхтэй хамтран ажиллана.



#### **Тээвэр, логистикийн бүтээн байгуулалт**

1. Олон улсын болон дотоодын зорчигч тээвэр, ачаа тээврийн төвийг шинэчлэх, хүчин чадлыг сайжруулах нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
2. Төрөлжсөн тээвэр, логистикийн төвүүдийг байгуулна.
3. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, махны хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулна.



*А. Воронин*




## 4. НИЙСЛЭЛЭЭ НОГООРУУЛЪЯ

### 4.1. Нийслэлээ ногооруулна.

Өнгөрсөн онд Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас зохион байгуулсан нийслэлийн 9 дүүргийн 204 хороог хамруулсан судалгааны үр дүнгээс харахад 68 хувь нь тохижилт, ногоон байгууламж хангалтгүй гэсэн үнэлгээ өгчээ. Ялангуяа хотод сүүлийн үед баригдаж байгаа барилга, орон сууц бүхий бүтээн байгуулалтууд цементэн ой болсон төдийгүй ногоон байгууламж, мод маш хангалтгүй байна.

Иймээс ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ-ээс ногоон байгууламжийг хөгжүүлэхэд онцгой анхаарч, идэвх санаачилгатай ажиллаж, эко орчныг бүрдүүлсэн ногоон хот болгоно.

1. Эх дэлхийгээ хайрлах, байгальд ээлтэй аж төрөх дадал зуршлыг төлөвшүүлэх, ногоон бизнес эрхлэх, ногоон орчинд ажиллаж, амьдрах Ногоон гарц санаачилгыг хэрэгжүүлнэ.
2. Мод тарих Ижий төгөл ажлыг орон даяар төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын түншлэлийн хүрээнд дэмжиж зохион байгуулна.
3. Сургууль, цэцэрлэгийн орчинд сурагч, эцэг эх, дүүрэг, сургуулийн оролцоотойгоор мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
4. Гэр хорооллын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх Ногоон ирээдүй санаачилгыг хэрэгжүүлнэ.
5. Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа хууль зөрчсөн барилгуудыг нураан нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлөх ажлыг үргэлжлүүлж, тохижилтын ажлын 60-80 хувьд ногоон байгууламж бүхий орчныг бий болгоно.
6. Орон сууцны дундах ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хотхон, хорооллуудын сууц өмчлөгчдийн холбоод, иргэдийн оролцоотойгоор дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгоно.
7. Нийслэл хотод тарьсан цагаан хөвөн гаргадаг моднуудыг үр нь задрахаас өмнө тогтмол арга хэмжээ авч ажиллана.



*А. Сүхбаатар*

#### 4.2. Ногоон бизнесийг дэмжинэ.

Сүүлийн жилүүдэд байгальд ээлтэй, ногоон бизнесийг дэмжих хандлага улам бүр нэмэгдсээр байна. Ногоон бизнесийг дэмжиж буй арилжааны банкууд хөнгөлөлттэй зээлээр ногоон санхүүжилтийг олгож эхэлсэн бөгөөд бүтээгдэхүүний савлагаа, хэрэглээ ногоон бизнесийг дэмжих гол нөхцлийг бүрдүүлж байна. Гэвч ногоон бизнес, санхүүжилтийн талаар бодлогын түвшинд бүрэн дэмжигдэж амжаагүй байна. Иргэд банк санхүүгийн ногоон зээлийн шалгуурыг хангаж чадахгүй байна.


Иймээс ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ-ээс ногоон бизнесийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, бодлогын түвшинд дэмжин тодорхой хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлнэ.

#### Ногоон санхүүжилт

1. Байгаль орчинд ээлтэй, ногоон технологийн дэвшил, хөгжүүлэлтийг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд өргөжүүлэн иргэдийг урт хугацаатай ногоон зээлд хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Гэр хорооллын иргэдэд зориулсан дулаан алдагдал багатай, сэргээгдэх эрчим хүч ашигласан, дэвшилтэт технологи бүхий байшин барих болон байшин, сууцаа дулаалахад төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хөтөлбөр хэрэгжүүлнэ.
3. Байгальд ээлтэй, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
4. Ногоон, инновацийг нэвтрүүлсэн бизнес эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийг шалгаруулан урамшуулах ажлыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хөтөлбөр хэрэгжүүлнэ.
5. Нийслэлийн худалдан авалтад ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

#### Байгальд ээлтэй бизнес

1. Монгол улсад үйлдвэрлэж, импортолж байгаа бараа, бүтээгдэхүүний чанарыг олон улсын түвшинд хүргэх, импортлосон бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавихын тулд шилдэг ногоон стандартыг мөрдөж Монгол хүний амьдралын чанар, үр ашгийг дээшлүүлнэ.
2. Амьдрах орчноо уур амьсгалын өөрчлөлтөд зохицуулан бэлтгэх, цаашдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах ногоон ирээдүй санаачилгыг эхлүүлж хэрэгжүүлнэ.
3. Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй үндэсний үйлдвэрлэгчдийг байгальд ээлтэй бизнесийн үйл ажиллагаа явуулахыг уриалж, ногоон бизнес эрхлэгчдэд зориулсан үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.
4. Байгаль орчинд ээлтэй, органик бүтээгдэхүүний инноваци шингэсэн үйлдвэрлэлийг дэмжинэ.
5. Бүтээгдэхүүний сав, баглаа боодолд байгальд сөрөг нөлөөгүй материал ашигласан аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.



*Handwritten signature*